



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН, УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Б. ЧОЙЖИЛСҮРЭН
ТАНАА

2018.01.29 № 261
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасны дагуу Үндэсний аудитын газрын 2019-2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төслийг батлуулахаар хүргүүлж байна.

Үндэсний аудитын газраас 2019-2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийг сонгохдоо Төрийн аудитын тухай, Төсвийн тухай хууль болон УИХ-ын тогтоол, Байнгын хорооны захиалгаар хийх аудитын зэрэгцээ иргэд, олон нийтийн анхаарлын төвд байгаа үнэн зөв хариу хүссэн болон төрийн аудитын байгууллагаас баримталж байгаа нэгдсэн бодлогын хүрээнд аудит хийж дүгнэлт гарган, УИХ, Засгийн газарт бодлогын зөвлөмж хүргүүлэх шаардлагатай эрсдэлтэй асуудлуудыг сонгон авч аудит хийхээр боловсруулсан болно.


Батлагдсан 2019-2023 онд гүйцэтгэх аудитын сэдэвт үндэслэн тухайн жилд гүйцэтгэх аудитын сэдвийг сонгож хуулийн дагуу жил бүр Төсвийн байнгын хороонд хүргүүлж батлуулан мөрдөж ажиллаж байх болно.

Үндэсний аудитын газрын 2019-2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төслийг хэлэлцэн баталж өгнө үү.

Тогтоолын төсөл, аудитын сэдэв, товч танилцуулгыг хавсаргав.

Таныг хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

/төсөл/

2018 оны ____ дугаар
сарын ____ -ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Аудитын хэтийн төлөвлөгөөний сэдэв батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Үндэсний аудитын газрын 2019-2023 онд гүйцэтгэх аудитын хэтийн төлөвлөгөөний сэдвийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан аудитын сэдвийг үндэслэн жил бүр гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний төслийг нарийвчлан боловсруулж, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулжбатлуулан мөрдөж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудитор /Д. Хүрэлбаатар/-т үүрэг болгосугай.

Гарын үсэг

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2019-2023 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДВИЙН САНАЛЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2018.01.23

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Үндэсний аудитын газар төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө боловсруулж ажиллана.”, 16.2-т “Үндэсний аудитын газар төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө боловсруулахдаа иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн аудитын сэдвийг сонгож, хүний болон санхүүгийн нөөц, хугацаа, хүрэх үр дүнг тусган Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэр гаргуулна.” гэж заасан байдаг.

Хуулийн энэхүү заалт өнөөдрийг хүртэл бүрэн хэрэгжихгүй байсан билээ.

Энэхүү заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны а/131 дугаар тушаалаар батлагдсан “Төрөлжсөн болон аймаг, нийслэл дэхь Төрийн аудитын газрын гүйцэтгэх аудитын сэдвийг сонгох, төлөвлөх, бүртгэх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналын төслийг боловсрууллаа.

Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналын төслийг боловсруулахдаа Үндэсний аудитын газрын төрөлжсөн аудитын газруудын аудитын багууд болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудаас санал авч, нэгтгэн дүн шинжилгээ хийсний зэрэгцээ иргэд олон нийтийн үнэн зөв хариу хүссэн, хүлээлттэй байгаа тулгамдсан асуудлуудад дүн шинжилгээ хийж аудитын төлөвлөгөөний төсөлд тусгасан болно.

Аудитын сэдвийн сонголтыг хийхийн тулд төрөлжсөн болон аймаг нийслэл дэхь Төрийн аудитын газрын 2012-2017 онд гүйцэтгэсэн аудитын сэдвийн судалгаа хийж сэдвийн давтамж, давхардал, эрсдэл зэргийг тооцож холбогдох байгууллагуудтай санал солилцож ажиллалаа.

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичигт хяналтын тогтолцоог орхигдуулсан байгааг төрийн аудитын байгууллагын гүйцэтгэж буй аудитаар орлуулах чиглэл баримталж Тогтвортой хөгжлийг үзэл баримтлалд тусгагдсан тэргүүлэх чиглэлийн салбаруудын үйл ажиллагаа, тогтолцоонд хийх аудитыг түлхүү гүйцэтгэх чиглэл баримталсан болно. Тухайлбал, “Нийгмийн тогтвортой хөгжил”-ийн хүрээнд жил бүр эрүүл мэнд, боловсролын салбарын нэг үйл ажиллагаа, тогтолцоонд аудит хийхээр, “Байгаль орчны тогтвортой хөгжил” –ийн хүрээнд жил бүр байгаль орчны нэг асуудлаар аудит хийхээр, “Эдийн засгийн тогтвортой хөгжил”-ийн хүрээнд жил бүр банк санхүүгийн болон стратегийн ач холбогдол бүхий асуудал, томоохон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд аудит хийхээр, “Тогтвортой хөгжлийн засаглал”-ийн хүрээнд жил бүр нэг хуулийн хэрэгжилтэд аудит хийхээр тусгасан болно.

Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналын төсөлд 2019 онд 14 аудит, 2020-2023 онуудад жил бүр 12 аудит гүйцэтгэхээр төлөвлөлөө.

Ер нь төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх аудитын сэдвийг сонгохдоо дараахь 3 чиглэлээр сонголт хийж аудитын сэдвийг сонгож байгаа билээ. Үүнд:

- Хуулиар цаглабар нь тогтоогдож үүрэг болгосон аудит
- Нийгмийн захиалгаар гүйцэтгэх аудит
- Төрийн аудитын байгууллагын бодлогын хүрээнд гүйцэтгэх аудит

Хуулиар цаглабар нь тогтоогдож үүрэг болгосон аудитуудыг 2019-2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналд тусгаагүй бөгөөд дээрхи аудитын сэдвүүд нь жил, жилийн төлөвлөгөөнд тусгагдан зохицуулагдах болно гэж үзэж байна.

Мөн санхүүгийн тайланд баталгаажуулалт хийх аудитууд нь Төсвийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа тул энэхүү төлөвлөгөөний төсөлд тусгаагүй бөгөөд төрийн аудитын байгууллагын бодлогоор төсөвт байгууллагын үйл ажиллагаанд хийх санхүүгийн аудитыг тусгасан болно.

Харин Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.20-д заасан “төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд, түүнчлэн төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийж дүгнэлт гаргах” гэсэн заалт хэрэгжээгүй өнөөг хүрсэн бөгөөд энэ заалтыг хэрэгжүүлэх зохилгоор бие даасан хоёр аудит болгон задалж жил бүр гүйцэтгэхээр тусгайлан оруулсан болно.

Нийгмийн захиалгаар гүйцэтгэх аудитаар 2019 онд Хадгаламж зээлийн хоршоонд мөнгөө хадгалуулаад алдсан иргэдийн хохиролыг барагдуулах ажлын явц, төрөөс хохирлын 50,0 хувийг барагдуулсаны эргэн төлөлтийн байдал болон Төрөөс иргэдэд олгож байгаа нийгмийн халамж, үйлчилгээний өнөөгийн байдал, үр дүн сэдвээр аудит хийж олон нийтэд бодитой мэдээлэл хүргэх, хүнсний аюулгүй байдлыг хангах өнөөгийн тогтолцоо, хэрэгжилт, үр нөлөө, Гадаадын анчдаар агнуулсан ан амьтны агнуурын нөөц ашигласны нөхөн төлбөр ногдуулалт, барагдуулалт, Төмөр замыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд аудит хийхээр төлөвлөлөө.

Төрийн аудитын байгууллагын бодлогын түвшинд хийх аудитын сэдвийг сонгохдоо төрийн аудитын байгууллагаас эрүүл мэнд, боловсролын салбарын тогтолцоонд ойрын 4 жилд багтаан иж бүрэн аудит хийхээр төлөвлөж байгаа бөгөөд 2019 онд Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр нөлөө, Мэргэжлийн боловсролын байгууллагын үйл ажиллагаа, үр дүн, Эмийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа гэсэн сэдвээр аудит хийхээр төлөвлөлөө. Дээрхи аудитын сэдвийн сонголтыг хийхийн тулд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Яам, Эрүүл мэндийн Яамны холбогдох хүмүүстэй уулзалт ярилцлага зохион байгуулж сэдвийн сонголт, хамрах хүрээний талаар санал солилцлоо. Энэ сэдвийг 2018 оны аудитын сэдвийн сонголтод оруулсан боловч Байнгын хорооны ажлын хэсэг дээр хасагдсан болно. Үүний зэрэгцээ Стратегийн ач холбогдол бүхий зарим ашигт малтмалын /тухайлбал, нефть, алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр, жонш / олборлолт, ашиглалтаас төрд ногдож буй ашгийн талаар аудит хийж дүгнэлт гаргах, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийхээр төлөвлөж байна. Мөн жил бүр нэг томоохон төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд иж бүрэн аудит хийж байхаар төлөвлөж байгаагийн дотор 2019 онд “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн, 2020 онд “Оюутолгой” ХК-ийн, 2021 онд “Монросцветмет” ХХК-ийн, 2022 онд “Улаанбаатар төмөр зам” ХН-ийн, 2023 онд “Эрдэнэтийн үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагаанд аудит хийхээр тусгалаа.

Энэхүү 2019-2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналаас 2019 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналыг авч тухайн жилд хуулиар үүрэг хүлээлгэсэн аудитын сэдвийг нэмж төлөвлөөд Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналын төслийг боловсруулсан болно.

Ингэснээр 2019 онд хуулийн дагуу 18 аудит, нийгмийн захиалгаар 5 аудит, төрийн аудитын байгууллагын бодлогоор гүйцэтгэх 6 аудит, нийт 29 аудит төлөвлөж байна.

Төрийн аудитын байгууллага 2018 оноос хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн горимд шилжиж байгаатай уялдуулан аудитын сэдэв бүр нэг хөтөлбөр болж төрийн аудитын байгууллагын төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл боловсруулах үндэслэл болох юм.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Их хурлын Байнгын хорооны 2018 оны 01
дүгээр сарын ___ ны өдрийн ___ дугаар тушаалын хавсралт

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС 2019-2023 ОНД
ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДВИЙН ТӨСӨЛ

2018.01.23

2019 ОН				
Дугаар	АУДИТЫН СЭДЭВ	ХАМРАХ ХҮРЭЭ	АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХЭЛБЭР	ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР
1	Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн	аймаг, нийслэл дэх БСГ, хувийн болон төрийн өмчийн цэцэрлэгүүд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
2	Мэргэжлийн боловсролын байгууллагын үйл ажиллагаа, үр дүн	БСШУСЯам, аймаг, нийслэл дэх МСҮТ	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
3	Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн	ЭМЯ, аймаг, нийслэл дэх ЭМГ, Эмийн эргэлтийн сангууд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
4	Төрөөс иргэдэд олгож байгаа нийгмийн халамжийн үйлчилгээний өнөөгийн байдал, үр дүн	ХНХЯ, Аймаг, нийслэл дэхь ХХҮХ	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
5	"Монголын цахилгаан холбоо" ХК-ийн үйл ажиллагааны үр дүн	Монголын цахилгаан холбоо ХК	өөрийн удирдамжаар	Хамтарсан аудит
6	Хүнсний аюулгүй байдлыг хангах өнөөгийн тогтолцоо, хэрэгжилт, үр нөлөө	ХХААХҮЯ, МХЕГ, хилийн боомт	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
7	Хадгаламж, зээлийн хоршооны өр барагдуулалтыг байдал	ХЗДХЯ, Банк, хадгаламж зээлийн хоршоодын өр барагдуулах ажлын алба	өөрийн удирдамжаар	Нийцлийн аудит
8	Төмөр замыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүн	ЗТЯ, "Монголын төмөр зам" ХХК, "Улаанбаатар төмөр зам" ХН	өөрийн удирдамжаар	Нийцлийн аудит
9	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын олборлолт, борлуулалт, экспортонд гаргаж буй үнэ, ашиг, алдагдал /алт, нефть, нүүрс, зэс, төмрийн хүдэр, жонш/	Сангийн Яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн Яам,	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
10	Гадаадын анчдаар ан агнуулсан ан амьтны агнуурын нөөц ашигласны төлбөр ногдуулалт, барагдуулалтын байдал /2012-2017 он/	БОАЖЯ, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Нийцлийн аудит
11	Газрын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн	Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл дэхь Газрын алба, сум дүүргийн ЗДТГ	Нэгдсэн удирдамжаар	Нийцлийн аудит

12	Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийж дүгнэлт гаргах	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
13	Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийж дүгнэлт гаргах	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
14	Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн хийсэн ажлын үр дүн	холбогдох байгууллагууд	өөрийн удирдамжаар	Аудитын төрөл бүрээр хийх давтан аудит
2020 ОН				
1	Төрөөс бага боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн	БСШУСЯ, аймаг, нийслэл дэх БСГ, хувийн болон төрийн өмчийн бага дунд сургуулиуд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
2	Өрхийн эмнэлэгийн үйл ажиллагааны үр дүн	ЭМЯ, аймаг, нийслэл дэх ЭМГ, өрхийн эмнэлэгүүд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
3	Хөрөнгийн биржийн үйл ажиллагаа ба иргэдийн үнэт цаасны хадгаламж, ногдол ашиг хуваарилалт, олголт	Монголын хөрөнгийн бирж, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК, "Арилжааны төлбөр тооцоо" ХХК	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
4	"Оюутолгой" ХК-ийн үйл ажиллагааны үр дүн	Сангийн Яам, "Оюутолгой" ХК	өөрийн удирдамжаар	Хамтарсан аудит
5	Засгийн газраас зарласан экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэрийн 888 төсөлд олгосон зээлийн ашиглалт, үр дүн, эргэн төлөлт	Сангийн Яам, Хөгжлийн банк	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
6	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
7	Баруун бүсийн эрчим хүчний хангамжийн өнөөгийн байдал,	ЭХЯ, Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан аймгийн ЗДТГ	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
8	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн	СЯ, БОАЖЯ, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний зөвлөл, нийслэлийн ЗДТГ	өөрийн удирдамжаар	Нийцлийн аудит
9	Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд хийх аудит	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит

10	Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийх	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
11	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр ашиг	Сангийн Яам, Үндэсний хөгжлийн газар, холбогдох газрууд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
12	Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн хийсэн ажлын үр дүн	холбогдох байгууллагууд	өөрийн удирдамжаар	Аудитын төрөл бүрээр хийх давтан аудит
2021 ОН				
1	Төрөөс суурь боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн	БСШУСЯ, аймаг, нийслэл дэх БСГ, хувийн болон төрийн өмчийн дунд сургуулиуд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
2	Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаа, эмийн үнийн хөнгөлөлтөд олгож буй хөрөнгийн зарцуулалт, үйлчилгээний хүртээмж	ЭМЯ, ЭМДЕГ, аймаг, нийслэл дэх ЭМГ	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
3	Монгол орны цөлжилтийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар	БОАЖЯ, Цөлжилт бүхий аймаг, суын ЗДТГ	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
4	"Монросцветмет" ХХК-ийн үйл ажиллагаа, үр дүн	Сангийн Яам, "Монросцветмет" ХХК	өөрийн удирдамжаар	Хамтарсан аудит
5	Тэтгэврийн даатгалын сангийн зарцуулалт, хэтийн төлөв	НДЕГ. Аймаг нийслэл дэхь НДХ	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын эд хөрөнгийн холбогдолтой шүүхийн шийдвэр бүрийн биелэлтийг хангах чиг үүргийн хэрэгжилт, үр дүн	ШЕЗ, ШШБЕГ, аймаг, нийслэл дэхь ШШБА	Нэгдсэн удирдамжаар	Нийцлийн аудит
7	Сэргээгдэх эрчим хүчний талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт, үр дүн	ЭХЯ, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэр, ААН	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
8	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, Төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалт, ажлын байрны томилгооны байдал	Төрийн албаны зөвлөл, аймаг, нийслэл, Яамдын салбар зөвлөл	Нэгдсэн удирдамжаар	Нийцлийн аудит
9	Сонгосон нэг аймгийн үйл ажиллагаанд иж бүрэн аудит хийх	Сонгосон аймгийн нийгэм, эдийн засгийн бүхий л салбар	өөрийн удирдамжаар	Хамтарсан аудит
10	Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийх	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит

11	Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийх	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
12	Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн хийсэн ажлын үр дүн	холбогдох байгууллагууд	өөрийн удирдамжаар	Аудитын төрөл бүрээр хийх давтан аудит
2022 ОН				
1	Төрөөс бүрэн дунд боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн	БСШУСЯ, аймаг, нийслэл дэх БСГ, хувийн болон төрийн өмчийн дунд сургуулиуд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
2	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр дүн	ЭМЯ, аймаг, нийслэл дэх ЭМГ, төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэгүүд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
3	Улс, орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын үр дүн	Сангийн Яам, аймаг, нийслэлийн ЗДТГ	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
4	"Улаанбаатар төмөр зам" ХН-ийн үйл ажиллагааны үр дүн	Сангийн Яам, "Улаанбаатар төмөр зам" ХН	өөрийн удирдамжаар	Хамтарсан аудит
5	Ойн нөөц, нөхөн сэргээлт, арчлалт хамгаалалт	БОАЖЯ, аймаг нийслэлийн БОАЖГазар	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
6	Сургалтын төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн	Сангийн Яам, БСШУСЯ, холбогдох байгууллагууд	өөрийн удирдамжаар	нийцлийн аудит
7	Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн	ХЗДХЯ, холбогдох байгууллагууд	өөрийн удирдамжаар	нийцлийн аудит
8	Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааны үр дүн	Сангийн Яам, холбогдох байгууллагууд	өөрийн удирдамжаар	нийцлийн аудит
9	Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийх	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
10	Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийх	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
11	ХХААХҮ-н салбарын үйл ажиллагаанд иж бүрэн аудит хийх	ХХААХҮЯ, харьяа байгууллагууд	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
12	Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн хийсэн ажлын үр дүн	холбогдох байгууллагууд	өөрийн удирдамжаар	Аудитын төрөл бүрээр хийх давтан аудит
2023 ОН				

1	Төрөөс дээд боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн	БСШУСЯ, аймаг, хувийн болон төрийн их дээд сургуулиуд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
2	Эрүүл мэндийн байгууллагын гол нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоо	ЭМЯ, аймаг, нийслэл дэх ЭМГ, эргэлтийн эмийн сангууд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
3	Улс, орон нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг, бүтэц орон тоо, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн	улс, орон нутгийн төсвийн байгууллагууд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
4	"Эрдэнэтийн үйлдвэр" ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн	Сангийн Яам, "Эрдэнэтийн үйлдвэр" ХХК	өөрийн удирдамжаар	Хамтарсан аудит
5	Хүүхдийн мөнгөний олголт, хэрэгжилт, үр дүн	Сангийн Яам	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
6	Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн тоо, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал	ХНХЯ, гадаадын иргэн, харьяатын газар	өөрийн удирдамжаар	нийцлийн аудит
7	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн	Сангийн Яам	өөрийн удирдамжаар	нийцлийн аудит
8	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн	БОАЖЯ, холбогдох байгууллагууд	Нэгдсэн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
9	Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийх	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
10	Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийх	Засгийн газар, Сангийн Яам	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
11	Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн	УУХҮЯам, холбогдох байгууллагууд	өөрийн удирдамжаар	Гүйцэтгэлийн аудит
12	Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн хийсэн ажлын үр дүн	холбогдох байгууллагууд	өөрийн удирдамжаар	Аудитын төрөл бүрээр хийх давтан аудит

СТРАТЕГИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд гүйцэтгэх аудитын сэдвийн санал

Салбар, чиглэл	2019	2020	2021	2022	2023
1. Боловсрол	1. Сургуулийн өмнөх боловсрол	1.бага боловсрол	1.суурь боловсрол	1.бүрэн дунд	1.Их дээд боловсрол
	2. МСУТ				
2. Эрүүл мэнд	3.Эмийн эргэлтийн сан	2.Өрхийн эмнэлэг	2.ЭМДсан	2.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	2.Эм, эмнэлэгийн тоног төхөөрөмж худалдан авалт
	4.Ан агналтын төлбөр ногдуулалт				
3 Байгаль орчин	5.МЦХолбоо	3.агаарын бохирдол	3.цөлжилт	3.ойн нөөц, нөхөн сэргээлт	3.БО-ны чиглэлийн зээл тусламжийн ашиглалт
	6.Нийгмийн халамж, үйлчилгээ				
4. ТӨААН	7. ХЗХоршооны ер барагдуулалт	4.Оюутолгой	4.Монросцветмет	4.УБТЗ	4.Эрдэнэтийн үйлдвэр
	5.Банк санхүү				
5 Банк санхүү	6.Нийгмийн халамж, үйлчилгээ	5.Хөрөнгийн бирж, ногдол ашиг	5.Тэтгэврийн даатгалын сан	5.Сургалтын төрийн сан	5.Хүүхдийн мөнгө олголт
	7. ХЗХоршооны ер барагдуулалт				
6. Хуулийн хэрэгжилт	8.Газрын тухай хуулийн хэрэгжилт	6.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	6.Төрийн албаны тухай хууль, томилгоо	7.Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт	6.Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт
	9.Төмөр замыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн				
7. Сан, төсөл, хөтөлбөр	10. Хүнсний аюулгүй байдал	7.888 төслийн хэрэгжилт	7. Сэргээгдэх эрчим хүч	8.Засгийн газрын тусгай сангууд	7.ЖДҮ-ийг дэмжих сан
	11. 6 нэрийн ашигт малтмал				
8.Стратегийн ач холбогдол бүхий арга хэмжээ	9.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр ашиг	8. Баруун бүсийн эрчим хүч	7. Сэргээгдэх эрчим хүч	8.Монгол Улсад ажил эрхэлж буй гадаад иргэд	8. Монгол Улсад ажил эрхэлж буй гадаад иргэд
	10. Хүнсний аюулгүй байдал				
9. Тогтолцооны аудит	11. 6 нэрийн ашигт малтмал	9.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр ашиг	8. Нэг аймаг	9. ХХААХҮЯ	9.Захирааны байгууллагуудын чиг үүрэг бүтэц
	12. 6 нэрийн ашигт малтмал				

10. Бусад	12. Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийж дүгнэлт гаргах	10. Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийж дүгнэлт гаргах	9. Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийж дүгнэлт гаргах	10. Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийж дүгнэлт гаргах	10. Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийж дүгнэлт гаргах
13. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийж дүгнэлт гаргах	11. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийж дүгнэлт гаргах	10. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийж дүгнэлт гаргах	10. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийж дүгнэлт гаргах	11. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийж дүгнэлт гаргах	11. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийж дүгнэлт гаргах
14. Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн ажлын үр дүн	12. Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн ажлын үр дүн	11. Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн ажлын үр дүн	12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын эд хөрөнгийн холбогдолтой шүүхийн шийдвэр бүрийн биелэлтийг хангах чиг үүргийн хэрэгжилт, үр дүн	12. Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн ажлын үр дүн	12. Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн ажлын үр дүн

СТРАТЕГИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР